

**Бодлогоор дамжуулан
сурагчдын бүтээлч сэтгэлгээг
хөгжүүлэх нь
/PISA-ийн бодлогууд/**

Математикийн багш Г. Дашмаа
Математикийн багш Э. Оюунцэцэг

Стандарт бус бодолго

Математик сургалт нь стандарт бодлогуудыг томъёо, дүрэм ашиглан бодох эсвэл стандарт бус бодлогуудыг бүтээлч сэтгэлгээнд үндэслэн шийдэх гэсэн хоёр өөр зорилготой үйлээр тодорхойлогдоно. Математикийн хичээлд стандарт бус бодлого хэрэглэснээр сурагчдын мэдлэгийг шинэ нөхцөлд хэрэглэх, задлан шинжлэх, нэгтгэх, загварчлах, эрэл хайгуул хийх, уян хатан хандах, шинэ арга, аргачлал нээх, санаагаа бүрэн гүйцэд хэрэгжүүлэх, оновчтой дүгнэлт гаргах зэрэг бүтээлч чадварын төлөвшилд нөлөөлөх боломжтой.

Бодлого 1.

8^{15} зэргээс 8^{16} нь 8 дахин их гэдэг нь үнэн үү?

Бодлого 2.

8^{10} зэрэг нь 8-аас 10 дахин их гэдэг нь үнэн үү?

Бодлого 3.

$(-5)^{43} + (-1)^{43} + (5)^{43}$ илэрхийллийн утгыг олоорой.

Бодлого 4.

7^{190} тооны төгсгөлийн цифр хэд вэ?

Бодлого 5

Хэрвээ 2 оронтой тоон дээр түүний цифрүүдийн байрыг сольж нэмбэл бүтэн квадрат болно. Энэ нөхцөлийг хангах бүх 2 оронтой тоог ол.

Бодлого 6

Зүүн захынх нь цифрийг баруун талд бичихэд 2 дахин ихэсдэг тоо байх уу?

Бодлого 7

Хайруулын тавган дээр 6 хуушуур хайрах болов. Нэгэн зэрэг 4-өөс ихгүй хуушуур хайрах боломжтой ба хуушуурын нэг талыг 5 минут хайрах бол үүнийг яаж хийх вэ?

Дүгнэлт

Хичээлийн эхний 5-10 минутад сурагчдын идэвх оролцоо, анхаарлыг нэмэгдүүлэх зорилгоор PISA –ийн шалгалтын даалгавруудаас ажиллуулж үзлээ. Сурагчдад их сонирхолтой байсан бөгөөд сурагчдын математикийн хичээлд оролцох идэвх оролцоо нэмэгдэж байгаа сайн тал ажиглагдлаа. Цаашдаа хичээлийн эхлэхийн өмнө сурагчдын идэвх оролцоог нэмэгдүүлж анхаарлыг нь төвлөрүүлэх, сэтгэлгээг нь хөгжүүлэх зорилгоор стандарт бус бодлого бодуулж байх нь зүйтэй гэсэн дүгнэлтийг гаргаж байна. Гэрийн даалгаварт 1 бодлого өгөв.